

БАТЛАВ:
СҮХБААТАР ДҮҮРГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
АЛБАНЫ ДАРГА Э.ЗОРИГОО

“ЗӨВШӨӨРӨЛГҮЙ БАРИГДСАН, АЛБАДАН БУУЛГАХ ТООСГОН ГАРААШ”-ИЙН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр

Дугаар 1901

Улаанбаатар хот

1.	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.4.1 дэх заалт;- Сүхбаатар Дүүргийн Засаг Даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.1.3 дэх заалт;- Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/227 дугаар захирамж;- Сүхбаатар дүүргийн Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, Газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөө батлах тухай 11/63 дугаар тогтоол;- Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн дүүргийн 2024 оны төсөв батлах тухай 11/67 дугаар тогтоол;
2.	Байршил, хэмжээ	Сүхбаатар дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 10 дугаар хороо (361 ш тоосгон гарааш)
3.	Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгон тухайн ажлын гүйцэтгэлийн чанараар гэрээг дүгнэж, цаашид гэрээг сунгах эсэхийг шийдвэрлэнэ.
4.	Гүйцэтгэх ажил	<ul style="list-style-type: none">- Зөвшөөрөлшүй тоосгон гараашуудыг албадан буулгах;- Буулгалтаас үүссэн хог хаягдлыг авч тээвэрлэх;- Захиалагчийн баталсан төсвийн хүрээнд гүйцэтгэгч нь газрын зөрчлийг арилгах, нийтийн эзэмшлийн зам, талбайг чөлөөлөх ажлыг гэрээний хугацаанд хийх;- Албадан хураагдсан эд зүйлийг харъяа дүүргийн Газар зохион байгуулалтын албаны газрын зөрчил, санхүү бүртгэл хариуцсан ажилтан болон газар зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн нартай нягт хамтран ажиллаж аливаа асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэх;
5.	Төслийн захиалагч	Сүхбаатар дүүргийн Газар зохион байгуулалтын алба
6.	Төсөл боловсруулах байгууллага	<ul style="list-style-type: none">- Барилга хот байгуулалтын яамнаас олгосон зөвшөөрөл бүхийн мэргэжлийн байгууллагын эрхтэй аж ахуй нэгж байна. (БА-2.1, БА-3.1, БА-6.1, БА-6.2, БА-6.3, БА-6.4, БА-7.1)- Гүйцэтгэгч нь шаардлагад нийцсэн ажлын ур чадвар, туршлага бүхий хүмүүсээр багаа бүрдүүлэх;

7.	Техникийн шаардлага	<ul style="list-style-type: none"> - Гүйцэтгэгч нь экскаватор, ачааны машин /хово/, маяти, портер, тасдагч, молоток, зөөврийн цахилгаан мотор, хүрз, жоотуу гэх мэт багаж техник хэрэгсэлтэй байна. - Мөн дээрх техник, тоног төхөөрөмжид иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж туслан гүйцэтгэгүүлж болно; - Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх, эхлэх бүрт ажилтан нэг бүрт аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангах, аюулгүй ажиллагааны журам зөрчсөн ажилтныг ажиллуулахгүй байх - Буулгалт, нүүлгэн шилжүүлэх, тээвэрлэх хэлбэрээр зөрчлийг арилгахдаа машин, техник хэрэгслийн сул зогсолт гаргалгүй, зохион байгуулалттай ажиллах
8.	Хүлээлгэн өгөх материал	<ul style="list-style-type: none"> - Ажлын тайлан 2 хувь; - Боловсруулсан тоон зураг хэвлэмэл 2 хувь;
9.	Хууль, тогтоомж, норм, дүрэм, стандарт	<p>Хууль тогтоомжууд:</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага стандарт - Машин механизм тоног төхөөрөмжид тавигдах шаардлага - Өргөх, зөөх тээвэрлэх механизмд тавигдах шаардлага - Барилгын тухай хуулийн 40.1.3, 40.1.5 - Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05
10.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэж болох ба үүнийг гэрээний тусгай нөхцөлөөр тодорхойлно.

БОЛОВСРУУЛСАН:

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ГАЗАР ЗОХИОН
 БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН/Ш.НАРАНЦОГТ/

